



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 08/26

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,
дахин тендер зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчин хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль-ийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус төвийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 09 дүгээр зөвлөмжийн дагуу хоол хүнсний материалын тендерийн 2 дугаар багц мах махан бүтээгдэхүүнийг 266,860,000 (Хоёр зуун жаран зургаан сая найман зуун жаран мянган) төгрөг, 3 дугаар багц гурил, гурилан бүтээгдэхүүнийг 27,180,000 (Хорин долоон сая нэг зуун наян мянган) төгрөгөөр тус тус Их-Өшгөг ХХК-аар, 4 дүгээр багц шош будааг 33,588,000 (Гучин гурван сая таван зуун наян найман мянган) төгрөг, 6 дугаар багц хүнсний ногоог 84,035,000 (Наян дөрвөн сая гучин таван мянган) төгрөг, 7 дугаар багц хүнсний нарийн ногоог 22,800,000 (Хорин хоёр сая найман зуун мянган) төгрөг, 8 дугаар багц жимс, жимсэн бүтээгдэхүүнийг 31,026,000 (Гучин нэгэн сая хорин зургаан мянган) төгрөг, 9 дүгээр багц хүнсний туслах бүтээгдэхүүнийг 75,291,200 (Далан таван сая хоёр зуун ерэн нэгэн мянга хоёр зуун) төгрөгөөр тус тус Эмт булаг ХХК-аар гүйцэтгүүлсүгэй.

2.Дээрх шалгарсан багцад гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авч ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Д.Баянмөнх), гэрээний хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Ерөнхий санхүүч (Г.Ганчөдөр) нарт даалгасугай.

3.Нэг ч оролцогч оролцоогүй 5 дугаар багц хуурай бүтээгдэхүүнийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар дахин зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Д.Аззаяа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Г.ДАШЖАНЦАН